



ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМ
СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН
ТУШААЛ

2016 оны 04 сарын 29 өдөр

Дугаар А/45

Улаанбаатар хот

Болзолт уралдаан зарлах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3.1, 9 дүгээр зүйлийн 9.4, Удирдлагын зөвлөлийн гишүүдийн 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Үйлчлүүлэгч, ажилтнуудад ээлтэй орчин бүрдүүлэх, ногоон байгууламж бий болгох зорилгоор “Бидний орчин-Бидний зүтгэл” болзолт уралдааныг 2016 оны 04 дүгээр сарын 28-ны өдрөөс 2016 оны 09 дүгээр сарын 31-ний өдрийг дуустал зохион байгуулсугай.

2. Болзолт уралдааныг дүгнэх комиссыг доорхи бүрэлдэхүүнтэй томилсугай.

Үүнд:

Комиссын дарга:	О.Баатаржав	Стратеги төлөвлөлт, хүний нөөцийн хөгжил эрхэлсэн дэд захирал
Нарийн бичгийн дарга:	Н.Оюунчимэг	Чанарын албаны дарга
Гишүүд:	О.Оюунтөгс	Сувилахуйн албаны дарга
	С.Ариунболд	Хүний нөөцийн ахлах мэргэжилтэн
	Л.Мөнхгэрэл	Эрүүл ахуйч бага эмч

3. Албад, поликлиник, клиникүүд, тасгууд, багуудын эрхлэгч, ахлагч нар өөрсдийн хариуцсан талбайгаа зүлэгжүүлэх, мод тарих, байнга услах, орчны тохижилт хийж, цэвэр цэмцгэр байлгахад онцгойлон анхаарч ажиллахыг үүрэг болгосугай.

4. Болзолт уралдааныг дүгнэх журмыг боловсруулан мөрдөж ажиллахыг Комиссын дарга, нарийн бичгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

